



**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ  
БУУРУУЛАХ ГАЗРААС 2023 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

1.1 Нэгдсэн үндэстний байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас дэвшүүлсэн уриаг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог хангах, аюулгүй амьдрах арга ухаанд сургаж, дадлагажуулах, гамшгийн эрсдэлийг бууруулахын ач холбогдлыг хүүхэд, залууст таниулахад чиглэгдэнэ.

**Хоёр. Хугацаа, хамрах хүрээ**

2.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь "Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр"ийг угтан жилийн хугацаанд 2023 онд дэвшүүлсэн уриалгын хүрээнд аян өрнүүлж, 2024 он 10 дугаар сарын 13-ны өдөр үр дүнг тайлагнах өдөрлөг зохион байгуулж, дараа жилийн буюу 2024 оны уриалгыг олон нийтэд таниулна.

2.2. Их дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулиудыг аянд өргөнөөр хамруулна.

**Гурав. Зохион байгуулалт**

3.1. Аймаг, нийслэлийн Засаг даргаар Нэгдсэн үндэстний байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2023 онд дэвшүүлсэн "Гамшигт тэсвэртэй ирээдүйн төлөө тэгш бус байдалтай тэмцэх нь" уриалгыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах удирдамж батлуулан, хэрэгжүүлнэ.

3.2. Төв, орон нутгийн хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган, тэдгээрийн 20-оос доошгүй хувийг хамруулан, мэргэжлийн байгууллагатай хамтран гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулна.

3.3. Сум, дүүрэг, баг хорооны Засаг даргын ажлын албатай хамтран, хамгийн өндөр настай иргэдийн судалгааг гарган, тэдгээрийн 30-аас доошгүй хувийг хамруулан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна.

3.4. Сум, дүүрэг, баг хорооны Эрүүл мэндийн төвтэй хамтран, жирэмсэн эхчүүдийн судалгааг гарган, тэдгээрийн 20-аас доошгүй хувийг хамруулан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна.

3.5. Сум, дүүрэг, баг хорооны бага насны хүүхэд болон асран хамгаалагч нарт гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна.

3.6. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалтын төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын 20-оос доошгүй хувийг хамруулна.

3.7. Нутгийн захиргааны байгууллагатай хамтран төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн орц, гарцад хяналт шалгалт явуулах, төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.8. Төөрсөн, байгаа газрын хаягийг мэдэхгүй байгаа тохиолдолд ашиглах 3 үсэгт "what3words" апплейкшныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар утсанд суулгах, таниулах, ашиглуулах талаар арга хэмжээг зохион байгуулна.

3.9. Төв, орон нутгийн ард иргэдэд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж, ухуулга сурталчилгаа, явуулах, гарын авлага, видео шторжийг тухайн орон нутгийн төрийн байгууллагуудын цахим хаягаар нийтлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.10. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

#### **Дөрөв. Аяны үр дүн, зардал**

4.1. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2024 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтний [khadbaatar@nema.gov.mn](mailto:khadbaatar@nema.gov.mn) цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан аяны үр дүнг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж, Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн дотор хүргүүлнэ.

4.3. Аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.